



## НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 7/55

Улаанбаатар хот

### Нийслэлийн иргэдийн спортын VIII наадмын бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Засаг даргын ивээл дор Нийслэлийн Иргэдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээн зохион байгуулахад шаардагдах хэвлэлийн эх бэлтгэх, хөтлөгч, телевизийн сурталчилгаанд шторк эх бэлтгэлийн ажлыг “Никель Декедь” ХХК-аар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан хариуцуулж, бэлтгэл ажлыг сайтар хангаж тэмцээнийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-д даалгасугай.

2. Нийслэлийн Иргэдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээн зохион байгуулах бэлтгэл ажлуудыг хангахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Нийслэлийн Иргэдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээн зохион байгуулах бэлтгэл ажлуудыг хангахад шаардагдах 3.500.000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн Спортын хорооны Спортын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБОЛД



1150500173

2019.10 sar Nikel - Copy.docx

Нийслэлийн Спортын хорооны даргын  
2019 оны *дөрөвдүгээр* сарын *18*-ны өдрийн  
*А.Б.С.* дугаар тушаалын хавсралт

Нийслэлийн иргэдийн спортын  
VIII наадмын хэвлэлийн эх бэлтгэх, хөтлөгч,  
телевизийн сурталчилгаанд шторк эх бэлтгэлийн  
ажлыг гүйцэтгүүлэх төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нийт дүн /төг/
1.	Сурталчилгааны анонс эх бэлтгэл, хэвлэл	160 м.кв	1.000.000
2.	Хөтлөгч	1	500.000
3.	Телевизийн сурталчилгаанд шторк эх бэлтгэл	30 сек	2.000.000
<b>ДҮН:</b>			<b>3.500.000</b>